

**ХКН-ЫН ҮНДЭСТНИЙ
БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ
(1982—1987 он)**

Ц.БАТБАЯР

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

ХКН-ын XII их хурал хуралдсанаас хойш XII их хурал хүртэлх 1982—1987 оны үе бол БНХАУ-ын нийгэм-улс төрийн амьдралд, тухайлбал хятад биш үндэстний амьдралд онцлог үйл явдалтай он жилүүд байлаа. Энэ хугацаанд Хятадын нөхцөлд үндэстний асуудлыг шийдэх үндсэн арга зам гэж үздэг үндэстний районы өөртөө засах¹ бодлогыг хэрэгжүүлэх талаар тодорхой алхмууд хийгдсэн байна. Энэхүү практик алхмуудыг ХКН-ын үндэстний бодлогод нийцүүлэн онолын хувьд үндэслэх гэсэн зарим оролдлого ч хийжээ.

1982 оны 9-р сард хуралдсан ХКН-ын XII их хурлын тайлан илтгэлд «үндэстний асуудлын ач холбогдлыг үндэстэн бүрийн эв нэгдэл, тэгш эрх ба тэдний хамтын мандал цэцэглэлт нь бүх орны хувь заяаг хөндсөн нэн чухал асуудал болно» гэж тодорхойлжээ.² Тус их хурлаас мөн үндэстний районуудын эдийн засаг, соёлыг хөгжүүлэх, «цөөнх үндэстний» өөртөө засах эрхийг хэрэгжүүлэх, олон үндэстний эв нэгдлийг бэхжүүлэхэд чиглэгдсэн улс төрийн чиг шугамыг цаашид тууштай баримтлах болно гэж заажээ.

ХКН-ын XII их хурал хуралдахын өмнө Хятад дахь үндэстний харилцааны мөн чанарыг хэрхэн тодорхойлох талаар өргөн санал солилцжээ. Үүнд «үндэстний асуудлын мөн чанар нь ангийн тэмцэл мөн» гэсэн «соёлын хувьсгалын» үеийн үндэслэлийг нийтээр шүүмжлэн буруушаах ажээ. Энэхүү үндэслэл нь удаан хугацаанд үндэстний бодлогыг завхруулж үндэстний харилцаанд асар их хохирол учруулжээ.

Үүний зэрэгцээ одоогийн шатанд үндэстний харилцаа нь үндсэндээ олон үндэстний хөдөлмөрчин ард түмний харилцаа болно гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл ангийн асуудал нь үндэстэн бүрийн дотоод харьцаанд, үндэстний асуудал нь олон үндэстний харьцаанд хамаарагдана гэж тайлбарлажээ.

Ийнхүү үндэстний асуудлыг дан ганц ангийн асуудал болгон хувиргаж, ангийн тэмцлийг зохиомлоор хэт дэвэргэж байсан явдлыг шүүмжилсэн нь зүй ёсны хэрэг юм. Гэвч ангийн тэмцлийн талаархи марксист - ленинист сургаалыг сэргээн баримталсан нөхцөлд энэ шүүмжлэл нь илүү үр дүнтэй болох бизээ. Марксизм-ленинизм үндэстний асуудалд хандахдаа түүнийг ангийн үүднээс шийдэхийг гол болгодог билээ. Иймд ангийн асуудал болон үндэстний асуудлын диалектик холбоог бүрмөсөн үгүйсгэхэд хүрвэл үндэстний хоорондын харилцааны ангийн агуулгыг хэрэгсэхгүйд хүргэж болох юм

ХКН-ын XII их хурлаас дэвшүүлсэн үндэстний районы өөртөө засах бодлогыг төгөлдөржүүлэх асуудал нь юуны өмнө энэ бодлогыг хууль зүйн баталгаатай болгохтой нягт холбоотой. 1982 оны 12-р сард батлагдсан БНХАУ-ын үндсэн хуульд үндэстний бодлогын асуудал урьд өмнөх үндсэн хуулиас илүү байр эзэлжээ. Үндсэн хуулинд БНХАУ-ын үндэстэн бүр тэгш эрхтэй бөгөөд үндэстэн бүрийн хууль ёсны эрх ба

ашиг сонирхолыг батлаж хамгаална гэж заажээ. Үндсэн хуулийн 4-р зүйлд хятад биш үндэстэн төвлөрөн суудаг районд үндэстний өөртөө засахыг хэрэгжүүлэх бөгөөд үндэстний районууд нь БНХАУ-ын салшгүй хэсэг гэж тунхаглажээ.³

1954 оны Үндсэн хуулинд тусгагдсан өөртөө засах үндсэн эрхүүдийг 1982 оны Үндсэн хуулинд бүрэн сэргээн тунхагласнаас гадна зарим заалтыг тодорхой баталгаатай болгосныг тэмдэглэх хэрэгтэй. Өөртөө засах байгууллагуудад орон нутгийн санхүүгээ хариуцан, соёл, шинжлэх ухаан, боловсрол, эрүүлийг хамгаалах болон биеийн тамирын салбарт асуудлыг бие даан шийдэх эрхийг олгожээ. Түүнчлэн тэдгээр нь тухайн районы аж ахуйг улсын төлөвлөгөөний дагуу зохицуулан эрхлэх ажээ. Мөн үндэстний районы байгалийн баялгийг нээн ашиглахад тус районы эрх ашгийг улс харгалзах болно гэсэн нэмэлт заалт оруулсан байна.

1982 оны Үндсэн хуулинд үндэстний район бүр өөрийн улс төр, эдийн засаг ба соёлын онцлогт нийцүүлэн өөртөө засах дүрэм болон орон нутгийн тусгай хууль тогтоомжийг боловсруулан хэрэгжүүлэх эрхтэйг ба талсан байна. Түүнээс гадна өөртөө засах район, өөртөө засах тойрог болон уезд (хошуу)-ын дарга нарыг автономит эрх эдэлж буй уг үндэстний төлөөлөгчөөс сонгон томилохыг хуульчлан бататгаж өгснийг тэмдэглэх хэрэгтэй.⁴

1982 оны Үндсэн хуулийн ерөнхий заалт дээр тулгуурлан үндэстний асуудлаархи хууль дүрмийг боловсронгуй болгох, хятад биш үндэстний өөртөө засах эрхийг тодорхой хуульчлан тогтоож өгөх шаардлага үүсчээ. Энэхүү хууль дүрмийг зохион боловсруулах явцад 1984 оны 5-р сард батлагдсан БНХАУ-ын Үндэстний районы өөртөө засах тухай хууль тодорхой нэгэн үе шат болсон юм⁵. 7 бүлэг 67 зүйл ангитай энэ хууль нь үндэстний өөртөө засах бодлогыг хэвээр хадгалсан бөгөөд түүнийг улс төр, эдийн засаг, соёлын болон бусад салбарт хэрэгжүүлэх арга замыг тодотгон тодорхойлж өгсөн байна. Юуны өмнө тус хуулинд үндэстний районы ардын төлөөлөгчдийн хурал болон ардын засгийн газрыг эмхлэн байгуулах талаар зарим нэмэлт заалт оруулсныг тэмдэглэвэл зохино. Үүнд тухайн районы АТХ-ын дарга буюу засгийн газрын дарга нь автономит эрхийг эдэлж буй уг үндэстний төлөөлөгч байх ёстойг бататган зааж өгчээ. Үүний зэрэгцээ АТХ болон Засгийн газрын бүрэлдэхүүнд тухайн үндэстний төлөөлөгчид «бололцооны хэрээр» багтаж орно гэж заалт орсон нь урьдах 1952 оны адил төстэй хуульд тухайн үндэстний төлөөлөгчид «чухал бүрэлдэхүүн хэсгийг» эзэлнэ гэж заасантай харьцуулбал нэг ёсны ухралт болжээ⁶.

Үндэстний өөртөө засах тухай хуулинд анхаарал татаж байгаа бас нэг заалт бол үндэстний районууд улсын хууль дүрэм, тогтоол журмыг амьдралд хэрэгжүүлэхдээ тухайн районы бодит байдлаас үндэслэн засварлан өөрчлөх буюу тохирохгүй бол хэрэгжүүлэхгүй байх тухай заалт болно. Энэхүү заалт нь цоо шинэ зүйл биш бөгөөд бүр 1980 онд Төвдийн талаар гаргасан ХКН-ын 8 зүйлтэй тогтоолын 3-р зүйлд хэрвээ ХКН-ын ТХ-ны чиг шугам, тогтоол, дүрэм, Төвдийн бодит нөхцөлд тохирохгүй бол хэрэгжүүлэхгүй буюу өөрчлөн хэрэгжүүлж болно гэж оржээ⁷. Энэ нь үндэстнийг районуудын бие даасан байдлыг тодорхой хэмжээгээр өргөтгөхөд чиглэсэн заалт учраас анхаарал татаж байна.

Үндэстний өөртөө засах эрхийг өргөтгөсөн эсэх тухай асуудал туйлын чухал юм. Тооны талаас авч үзвэл өөртөө засах эрхийн тухай заалт ихээхэн нэмэгджээ. 1952 оны адил төстэй хуульд энэ чиглэлээр 11 зүйл

байсан бол 1984 оны хуульд даруй 27 зүйл болж нэмэгджээ. Гэвч чанарын талаас авч үзвэл бие биенийгээ үгүйсгэсэн зөрчилтэй зүйлүүд багагүй ажиглагдаж байна. Тухайлбал тус хуулийн 22-р зүйлд үндэстний районууд нь тухайн уугуул үндэстний дундаас удирдах ажилтан, мэргэжилтэн ба мэргэшилтэй ажилчдыг их хэмжээгээр бэлтгэнэ гэж заасан бол 64-р зүйлд төрийн дээд байгууллагууд нь үндэстний районд ажиллуулахаар зохих тооны багш, эмч, инженер-техникийн ба удирдах ажилтныг илгээх талаар олон төрлийн арга хэмжээ авч байхаар заасан нь өөр хоорондоо авцалдаа муутай болжээ.

Үүний зэрэгцээ үндэстний өөртөө засах тухай хуулинд Хятадад явагдаж байгаа аж ахуйн шинэчлэлт, «нээлттэй хаалгын» бодлого зэрэг шинэ нөхцөл байдалтай уялдуулан үндэстний районуудын эрхийг өргөтгөхөд чиглэсэн зарим заалтыг нэмэн оруулжээ. Үндэстний районууд Төрийн зөвлөлийн зөвшөөрлөөр гадаад эдийн засгийн болон худалдааны харилцаа хөгжүүлэн, гадаад худалдааны бааз боомт байгуулах, мөн онцлог байдлаа харгалзан бэлчээр өмчлөх, ашиглах эрхийг боловсруулан хэрэгжүүлэх, түүнчлэн үндэстний районууд шаардлагатай гэж үзвэл хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах дүрэм журмыг боловсруулах эрхтэй гэж заажээ.

Үндэстний харилцааны тухай өгүүлсэн 5-р бүлгийн 6 зүйл дотроос нэг зүйл анхаарлыг татаж байна. Тус зүйлд үндэстний районуудад үндэстний боловсон хүчин хятад хэлийг сурч эзэмшихээс гадна хан үндэстний боловсон хүчин тухайн үндэстний хэлийг сурч эзэмших үүрэгтэйг заажээ. Хоёр болон түүнээс илүү хэл бичиг сурч эзэмшсэн улсын албан хаагчдыг урамшуулах тухай заалтыг мөн тусгажээ⁸.

Энэхүү хуулийг хэлэлцэхэд оролцсон Өвөр Монголын төлөөлөгчидтэй уулзсан уулзалт дээр тэр үед ХКН-ын Төв Хорооны УТТ-ны гишүүн байсан Улаанхүү хэлэхдээ тус хууль нь урьдын хууль дүрэмтэй харьцуулбал харьцангуй тодорхой, харьцангуй боловсронгуй боловч нэлээд асуудлууд, тухайлбал үндэстний өөртөө засах бодлогын онолын зарим асуудал цаашдын боловсруулалт, шийдвэрийг шаардаж байгааг тэмдэглэсэн байна. Түүнчлэн Улаанхүү тус хуулийг сурталчлан ухуулах, хэрэгжүүлэх, биелэлтийг хянах явдлыг анхааруулсан байна. Энэ гурван арга хэмжээг нягт уялдаатай явуулахгүй бол ямар ч хууль дүрэм хоосон цаас болж хувирна гэж онцлон заажээ⁹.

1984 оны 10-р сарын 1-нээс эхлэн хэрэгжсэн Үндэстний өөртөө засах тухай хуулийн нэг чухал зорилт бол үндэстний районууд нь өөрийн онцлогт тохируулан өөртөө засах дүрэм, орон нутгийн тогтоол журмыг боловсруулахад түлхэц өгөх явдал байв. Гэвч өнгөрсөн хугацаанд ганц нэгхэн жишээг эс тооцвол энэ ажил туйлын хангалтгүй явагдаж байгааг хятадын хэвлэл тэмдэглэж байна. Тухайлбал 1985 онд Цилинь мужийн Янь-бянь Солонгосын өөртөө засах тойргийн өөртөө засах дүрэм батлагдаж мөн оны 10-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон нь дээрх 1984 оны хууль батлагдснаас хойших анхны орон нутгийн өөртөө засах дүрэм гэж тооцогдож байна¹⁰.

Өнөөгийн шатан дахь ХКН-ын үндэстний бодлогын үндсэн чиг шугамын нэг нь Хятад дахь олон үндэстний нэгдлийг бэхжүүлэхэд чиглэгдэж байна. 1981 оны 10-р сард Хятад биш ард түмний төлөөлөгчдийн өмнө ХКН-ын ерөнхий нарийн бичгийн даргын дэвшүүлсэн «хэн нь хэнээс ч салж болохгүй» гэсэн заалт нь¹¹ эхний үед үндэстний районд явуулах боловсон хүчний бодлого буюу хан үндэстний боловсон хүчин «цөөнх

үндэстний» боловсон хүчнээс салж болохгүй, «цөөнх үндэстний» боловсон хүчин эргээд хан үндэстнийхээс салж болохгүй гэсэн утгатай байсан бол ХКН-ын XII их хурлаас хойш хан болон хан биш ард түмний харилцааны гол зарчим гэж тооцогдох болов. Өөрөөр хэлбэл ханьчууд бусад үндэстнээс салж болохгүй, бусад үндэстэн ч ханьчуудаас салж болохгүй гэсэн утгатай ажээ.

Энэхүү зарчмыг олон үндэстний харилцаанд хэвшүүлэхийн тулд 1982 оноос эхлэн үндэстний болон олон үндэстний зарим муж, хотод «үндэстний эв нэгдлийн шилдэг төлөөлөгчдийг сайшаан урамшуулах их хурал» хуралдуулах зэрэг зарим тодорхой арга хэмжээ авч байна. 1982 оны 11-р сард Синьцзян-Уйгурын ӨЗО-нд анх болсноос хойш ийм их хурал зөвхөн 1983 онд Хятадын ӨЗО мужид 8 удаа болсон байна. ӨМӨЗО-нд 1983 оны 9-р сарын 15—19-нд болсон ийм их хуралд 27 үндэстний 1034 төлөөлөгч оролцсон байна. 1984 оноос эхлэн үндэстний районуудад, жишээлбэл ӨМӨЗО-нд үндэстний эв нэгдлийн шилдэг төлөөлөгчдийг сайшаан урамшуулах сарын ажил гэдгийг жил бүр зохион явуулах болов.

Үүнээс үзвэл үндэстний эв нэгдлийг бэхжүүлэх асуудал нь ХКН-ын үндэстний бодлогын тулгамдсан асуудлын нэг болж тавигдаж байгаа нь илэрхий. Гэвч үндэстний эв нэгдлийг бэхжүүлэх нь үндэстний харилцаа нь бусад суурилаг шинж чанартай асуудлууд, тухайлбал эдийн засаг болон соёлын салбарт хамаарагдах асуудлыг хэрхэн шийдвэрлэхээс шууд хамаарна гэдгийг тэр болгон анхаарахгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Хятадын олон үндэстний хооронд «бодит тэгш бус байдал»¹² жинхэнэ хэрэг дээрээ оршоор байгааг хүлээн зөвшөөрч, түүнийг хэрхэн арилгах тухай асуудлыг үндэстний асуудлаархи онолын судлаачид өргөн бичиж хэлэлцэх болов. Эдний дотроос үндэстний онолын зарим асуудлаар Лю Сяньчжаогийн бичсэн өгүүлэл анхаарал татаж байна. Тэрээр үндэстний хоорондын «бодит тэгш бус байдал» болон ихэвчлэн хан үндэстэн оршин суудаг муж ба үндэстний районуудын хоорондын эдийн засаг-соёлын хөгжлийн тэнцвэргүй байдал хоёр нь өөр шинж чанартай ялгаатай зүйл гэж үзжээ¹³. Түүний үзсэнээр «бодит тэгш бус байдал» нь гол төлөв нийгмийн хөгжлийн шалтгаанаар «түүхээс уламжлагдан» үлдсэн байхад хөгжлийн тэнцвэргүй байдал нь газар зүй, цаг агаар, үйлдвэрлэлийн нөхцөл зэрэг бодит шалтгаанаар үүссэн гэлээ. Хоцрогдсон үндэстэн хөгжилтэй үндэстний түвшинд дөхөж ирсэн буюу гүйцэж ирсэн тодорхой нөхцөл, тодорхой цаг үед үндэстний хоорондын «бодит тэгш бус байдал» арилах бөгөөд энэ нь урт удаан хугацааг шаардах нь маргаангүй, тухайлбал Хятад орон хөгжилтэй социалист орнуудын түвшинд хүрч ирэх тэр үед энэ зорилт хэрэгжиж магадгүй юм гэж Лю Сяньчжао үзжээ. Харин муж, районуудын хоорондын эдийн засгийн хөгжлийн тэнцвэргүй байдал нь хэзээ ч бүрмөсөн арилахгүй бөгөөд учир нь хоцрогдсон район хөгжилтэй мужийн түвшинд хүрэхэд дахиад л шинэ тэнцвэргүй байдал үүсэх учраас энэ нь харьцангуй ойлголт болно гэж тэр тайлбарласан байна.

Хэдийгээр үндэстний хоорондын «бодит тэгш бус байдал» болон районуудын хоорондын хөгжлийн тэнцвэргүй байдлыг бүрмөсөн адилтгаж болохгүй боловч энэ хоёр ойлголт нь хоорондоо нягт уялдаа холбоотойг үгүйсгэж болохгүй. Зөвлөлтийн судлаач Гельбрасын үзсэнээр БНХАУ-ын муж районуудын эдийн засгийн, ялангуяа аж үйлдвэрийн хөгжлийн тэнцвэргүй байдал нь сүүлийн жилүүдэд хэвээр байгаа төдийгүй тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байна.¹⁴ Үүнийг Хятадын тоо баримт ч нотолж байна. Жишээлбэл 1983—1984 онд Хятадын бүх орны аж үйлдвэр хөдөө

аж ахуйн үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүн 14,2% өссөн байхад, үндэстний районых 9,8% өссөн байна. Үндэстний районы нийт бүтээгдэхүүний бүх орныход эзлэх хувийн жин нь 7% -д хүрч ядаж байх бөгөөд нэг хүнд ноогдох бүтээгдэхүүн нь бүх орны дунджаас 45%-иар бага байна¹⁵.

Түүнээс гадна үндэстний районуудын хоорондын хөгжлийн зөрөө мэдэгдэхүйц ялгаатай байна. Хятадын хэвлэлд бичсэнээр үндэстний районуудыг эдийн засгийн хөгжлийн түвшингийн хувьд гурав ангилж болно гэжээ. Үүнд нэгд хүн амынхаа идэх уух, өмсөх зүүх асуудлыг шийдвэрлэхээд чинээлэгжүүлэх замд яваа арай илүү хөгжилтэй районууд, хоёрт идэх уух, өмсөх зүүх асуудлыг үндсэнд нь шийдвэрлэсэн боловч үйлдвэрлэлээ хөгжүүлэх тогтвортой замд орж чадаагүй районууд, гуравт хүн амын идэх уух, өмсөх зүүх асуудлыг шийдвэрлээгүй, ядуу зүдүү байдлаас ангижраагүй районууд гэж хуваажээ. Гуравдахь ангилалд багтаж байгаа районууд хятад биш үндэстэн оршин суудаг бүх нутаг дэвсгэрийн тал хувийг эзлэх бөгөөд хятад биш хүн амын 1/3-ийг багтаасан байна гэж тооцоолжээ¹⁶.

Сүүлийн үед үндэстний асуудлаархи хятадын сонин хэвлэлийн материалд үндэстний ажилд эдийн засгийн хөгжлийг голлон, тэдний улс төр, эдийн засаг, соёлыг бүх талаар хөгжүүлэн, үндэстэн бүрийн хамтын мандал цэцэглэлтийг хангах тухай их ярьж бичих болов. Үндэстэн бүрийн хамтын мандал цэцэглэлт гэдэг ойлголт нь үндэстнүүд үндэстний онцлогоо алдаж бие биендээ уусах тухай соёлын хувьсгалын үеийн ойлголтын эсрэг үзэл болон гарч ирсэн бололтой. Өнөөгийн нөхцөлд энэ ойлголтыг хятадын судлаачид социалист шинчлэлтийг хэрэгжүүлэх социалист шинэчлэлтийг хэрэгжүүлэх явцад нэг бүлэг хүн, нэг бүлэг район түрүүлж чинээлэгжих бөгөөд эцэст нь бүгд нийтээр чинээлэгжих болно гэсэн үндэслэлээс үүдэн тайлбарлаж байна. Тухайлбал Исмаил Айматын бичсэнээр харьцангуй тэргүүний үндэстэн нь харьцангуй хоцрогдсон үндэстэндээ хариуцлагатай туслан үндэстэн бүрийн хамтын хөгжил, хамтын цэцэглэлтийг хэрэгжүүлэх нь тэргүүний үндэстний түүхэн үүрэг гэж үзжээ¹⁷.

Үүний зэрэгцээ үндэстний ажлын үндсэн чиглэл нь эдийн засгийн хөгжилд чиглэгдэх ёстойг онцлон тэмдэглэж байна. Үүний үндсэн шалтгааныг үндэстний районуудын эдийн засгийн хөгжлийн хурдац Хятадын бүх орны дундаж хурдцаас мэдэгдэхүйц доогуур бөгөөд тэдний хоорондох зөрөө ихэсч байгаагаар тайлбарлаж байна. Түүнээс гадна одоо хүртэл хятад биш үндэстний 15 сая хүн ам идэх уух өмсөх зүүх асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй бөгөөд тэдний үлэмж хэсэг нь туйлын хүнд гачигдалтай байгааг хүлээн зөвшөөрч байна¹⁸.

1987 оны 10-р сард хуралдсан ХКН-ын XIII их хурал үндэстний асуудалд урьдын адил анхаарч «улс орны нэгдлийг бэхжүүлэх, үндэстний тэгш эрх, эв нэгдлийг баримтлах ба үндэстэн бүрийн хамтын мандал цэцэглэлтийг хангах нь улс орны хувь заяаг хөндсөн нэн чухал асуудал» гэж тодорхойлсон байна¹⁹. Үүний зэрэгцээ үндэстний районы өөртөө засахыг цаашид төгөлдөржүүлэх, «цөөнх үндэстний» кадр боловсон хүчнийг их хэмжээгээр бэлтгэх шаардлагыг ихэд чухалчилжээ.

ХКН-ын хоёр их хурлын хооронд үндэстний асуудлаархи онол-практикийн салбарт хэрэгжүүлсэн зарим алхмыг авч үзвэл дараахь зүйлийг тэмдэглэж болох байна. Юуны өмнө үндэстний асуудлыг ангийн асуудлаар орлуулж, үндэстний бүхий л асуудлыг ангийн тэмцлийн хэлбэрээр шийдэж байсан урьдах алдааг залруулж үндэстний асуудлын урт удаан, ээдрээ зөрчилтэй шинж чанарыг сэргээн тогтоожээ. Социализмын үед

үндэстэн бүр уусаж нэгдэх биш харин хөгжин бадарч байх хамтын цэцэглэлтийн үе гэсэн ойлголтыг дэвшүүлсэн байна.

Мөн хятад биш үндэстнүүд өөрсдийн өөртөө засах эрхийг эдэлж хэрэглэх явдлыг хуульчлан журамлаж, хууль ёсны баталгаатай болгох талаар тодорхой зарим арга хэмжээ авчээ. Энэ нь урьд өмнө «их үсрэлт», «соёлын хувьсгал» зэрэг улс төрийн кампанит хөдөлгөөний үед хятад биш ард түмний өөртөө засах эрх мэдлийг дур зоргоор зөрчиж байсан тийм адал балмад явдлыг дахин гаргуулахгүй байх зорилготой бололтой.

1. Үндэстний районы өөртөө засах бодлого гэдэг нь аливаа үндэстэн салан тусгаарлаж тусдаа улс байгуулах хүртэл эрхтэй үндэстний өөртөө засах тохинох бодлогоос ялгаатай бөгөөд тухайн үндэстний төвлөрөн суудаг районд хэрэгжүүлэх

үндэстний орон нутгийн автономийг хэлнэ.

2. XII Всекитайский съезд Коммунистической партии Китая (документы), Пекин, 1982, с. 54

3. КНР. Конституция в законодательные акты М., 1984, с. 24

4 КНР. Конституция и законодательные акт. М., 1984, с. 52

5. «Жэньминь жибао» 1984. 06. 04

6. Основные нормативные акты о местных органах государственной власти и государственного управления КНР М., 1956, с. 66

7. В. А. Богословский. Политика «единого фронта» в Тибете. «Проблемы Дальнего Востока», 1981. No 2, с. 86—87

8. «Жэньминь жибао» 1984. 06. 04

9. «Жэньминь жибао» 1984. 05. 25

10. «Миьцзу туаньцзе», 1985, No 11

11. «Жэньминь жибао» 1981. 10. 05

12. Бодит тэгш бус байдал гэдэг нь хуулиар батлагдсан үндэстний хоорондын улс төрийн тэгш эрхийг биш, харин жинхэнэ амьдрал дээр тэдний хооронд оршиж буй эдийн засаг-соёлын тэгш бус байдлыг хэлнэ.

13. «Чжунянь миьцзу сюэюань сюэбао, 1986. No 1, с. 3—8

14. Е. Г. Гельбрас. Социально-экономические аспекты национального строительства в КНР. «Рабочий класс и современный мир», 1984. No 2, с. 78

15. Миьцзу яньцзю» 1986 No 1, с. 46—47

16. Мөн тэнд

17. «Жэньминь жибао» 1987. 05. 28

18. «Миьцзу туаньцзе» 1987. No 9, с. 5

19. «Жэньминь жибао» 1987. 11. 04

ХЯТАДЫН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ЭРГЭЛТИЙН ҮЕ

(ХКН-ын ТХ-ны 1978 оны III бүгд хурлын 10 жилийн ойд)

Д. БАЯСГАЛАН

ХКН-ын болон Хятад орны амьдралд түүхэн ач холбогдол бүхий ХКН-ын ТХ-ны 1978 оны III бүгд хурал нь урьд өмнөх бүгд хурлуудаас олон талаар ялгаатай болсон юм. Тухайлбал, Бүгд хурал хятад орны эдийн засгийг хөгжүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлж, хятадын удирдлагаас баримталж байсан зарим нэгэн алдаатай бодлогыг тодорхойлон дүгнэжээ. Бүгд хурлыг хуралдуулахын өмнө Хятадын бүх мужийн